ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ П.СҮХБААТАРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1 | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал.<br>Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчид гаалийн хяналт тавих нийтлэг журмыг шинэчлэн боловсруулахад харьяа гаалийн газар, хороодоос болон нэгжүүдээс санал авч эрх зүйн актад нийцүүлж, нэгжийн чиг үүргийн хүрээнд санал, төсөл боловсруулагдсан байх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | 1.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд хилийн хорио цээрийн хяналтын чиг үүргийг нэмж, холбогдох судалгаа, тайлбар хийж шинэчлэн боловсруулсан байна. | ***“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”*-ын төсөлд санал өгсөн талаар**<br>-Хяналт, бүрдүүлэлтийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №01101/236 дотоод зурвасын хавсралтаар ирүүлсэн “Журам батлах тухай” Гаалийн ерөнхий газрын даргын тушаалын төсөл, “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөлд дараах зарчмын болон найруулгын санал хүргүүлсэн. Үүнд:<br>**Зарчмын санал**<br>1.Журмын төслийн 1.2.1 дэх заалтын “эрүүгийн гэмт хэргийн” гэснээс агуулга давхардсан тул “эрүүгийн” гэснийг хасах.<br>2.Журмын төслийн 5.20 дахь хэсгийн “албан хаагч” гэсэн нэр томьёонд ямар этгээд хамаарах нь тодорхойгүй тул “гаалийн улсын байцаагч” гэж өөрчлөх.<br>3.Журмын төслийн 5.57 дахь хэсэгт заасан барааны нэр, төрөл, үнэ, ангилал буруу мэдүүлсэн, мэдүүлээгүй бараа илэрсэн зэрэг үйлдлүүд зарим тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үр | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагавартай тул мөн Эрүүгийн хуулийн хариуцлагатай холбогдох зохицуулалтыг тус хэсэгт нэмэх.<br><br>4. Журмын төслийн “гаалийн болон хорио цээрийн хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч” гэсэн нь гаалийн болон мэргэжлийн хяналтын хоёр тусдаа байгууллагын байцаагч гэж ялгаатай үзэхээр байх тул “гаалийн улсын байцаагч” гэж өөрчлөх.<br><br>5. Журмын төслийн “Зургаа.Гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлт, хяналт” бүлэг буюу гарах чиглэлд гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой харилцааны зохицуулалт тусгагдаагүй тул “Тав.Гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлэх, гаалийн хяналт тавих” бүлгийн нэгэн адил дээрхтэй холбогдсон зохицуулалт тусгах.<br><br>6. Журмын төслийн 7.1-ийн “хийх.” гэснийг “хийхдээ доор дурдсаныг баримтална:” гэж өөрчлөх.<br><br>7. Журмын төслийн 8.15-ын “лац, ломбыг” гэснийг “битүүмжлэлийг” гэж өөрчлөх.<br><br>8. Журмын төслийн 10.19-ийн “ирүүлнэ.” гэснийг “ирүүлэх бөгөөд шалгалт хийх эрх олгосон тухай гаалийн байгууллагын итгэмжлэлийг шуудангийн салбарын эрхлэгч авсан байвал зохино.” гэж өөрчлөх.<br><br>**Найруулгын багц санал:**<br><br>9. Журмын төслийн 1.15-ын “дэх заалтын” гэснийг “дэх хэсгийн” гэж, 1.16-гийн 4 дэх заалтын “байаагч” гэснийг “байцаагч” гэж, 1.16-гийн “гаалийн улсын улсын байцаагч” гэснийг “гаалийн улсын байцаагч” гэж, 1.16-гийн “гаалийн улсын улсын байцаагч” гэсний дараах “хэмээнэ” гэснийг “гэнэ” гэж, 1.17-гийн “нөхцлийг” гэснийг “нөхцөлийг” гэж, 2.4-ийн “1.14-д” гэснийг “1.14-т” | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэж, 4.2, 4.3-ын “35.3-д” гэснийг “35.3-т” гэж, 4.4-ийн “1.14-д” гэснийг “1.14-т” гэж, 5.63-ын “Энэ” гэснийг “энэ” гэж, 6.9-ийн дэд хэсгийн ““Гүний” гэсний “Гүний” гэж, 7.1.14-ийн “Бүрдүүлэлтийн” гэснийг “бүрдүүлэлтийн” гэж, 8.4-ийн “журмын” гэснийг “журам,” гэж, 8.14-ийн “хуулийн” гэснийг “хуульд” гэж, 9.1-ийн “хариусан” гэснийг “хариуцсан” гэж, 10.10-ын “тоо хэмжээ” гэснийг “тоо хэмжээ,” гэж, 10.20-ын “Гаалийн” гэснийг “гаалийн” гэж, 11.10-ын “Гаалийн” гэснийг “гаалийн” гэж, 11.17-гийн “хууль, тогтоомж” гэснийг холбоо үг тул “хууль тогтоомж” гэж, 13.9 дэх хэсгийн “хийсэнээс” гэснийг Монгол үсгийн зөв бичих дүрэмд нийцүүлж “хийснээс” гэж, 13.12-ын “13.6.-д” гэснийг “13.6-д” гэж тус тус өөрчлөх.<br>10. Тушаалын төслийн Үндэслэх хэсгийн “232.2,” гэснийг “232.2” гэж, “дахь заалт” гэснийг “дахь заалт,” гэж, 2 дахь заалтын “дор” гэснийг “доор” гэж, “тогтоосугай” гэснийг “тогтоосугай:” гэж өөрчлөх.<br>11. Тушаалын төслийн 3 дахь заалтын “үүрэг болгосугай.” гэсний өмнө “тус тус” гэж нэмэх.<br>12. Журмын төслийн 11.2-ын “гаалийн болон хорио цээрийн” гэснийг агуулга давхардсан тул хасах.<br>13. Журмын төслийн хавсралтын 15-ын “эсхүл” гэсний өмнө нэг зай авах, “хийсэн” гэсний дараах, мөн Тушаалын төслийн 3 дахь заалтын “(Ч.Тамираа)” гэсний дараах илүү зайг илүү зайг шахах.<br>14. Журмын төслийн 1.16-гийн заалтуудыг дугаарлах.<br>2.Иргэний нисэхийн ерөнхий газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 02/2330 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Монгол Улсын агаарын хилийн орох цэгээр нэвтрэн орж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ирсэн гадаадын болон Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг олон улсын хилийн боомтоор тогтоогдоогүй нисэх буудалд онцгой нөхцөл байдлын улмаас аргагүйдсэн буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний журам"-ын төсөлтэй танилцаж 2024 оны 10 дугаар сар болон 2025 оны 01 дүгээр сард Хяналт, бүрдүүлэлтийн газартай хамтран 2 удаагийн албан бичгээр санал өгч ажилласан бөгөөд тус журам ИНЕГ,ГЕГ,ХХЕГ,ГИХГ-ын даргын 2025 оны 02 сарын 21-ний өдрийн №А/43,А/59, №А/03,А/59 хамтарсан тушаалаар батлагдсан.<br><br>3.ДХАБХ-т 2025.01.03-ны өдрийн 25/02 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам"-ын төсөлтэй танилцаж хариуг 10 дугаартай дотоод зурвасаар хариу өгсөн.<br><br>4.Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хурлаас Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсээс боловсруулсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам"-ын төслийн зарим зүйл, хэсэг нь ХШҮДАГ-ын үндсэн чиг үүрэг, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай давхцаж байгаа эсэх талаар хэлэлцэж нэг мөр болгох чиглэлийг өгсний дагуу Хуулийн хэлтсээс ДХАБХ, ХШҮДАГ-тай хамтран дээрх асуудлаар хэлэлцүүлгийг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж журмын төсөлд 2025.01.09-ний өдрийн 20 дугаартай дотоод зурвасаар саналаа хүргүүлсэн.<br><br>5.Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс ирүүлсэн "Зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөлд Сангийн яамнаас ирүүлсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саналыг хэрхэн тусгасан байдлыг тус хэлтсийн ГУБ Н.Отгонцэцэгийн хамт хянаж хүргүүлсэн.<br><br>6.Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн ахмадын хорооноос ирүүлсэн Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/290 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Ахмадын сангийн журам”, хоёрдугаар хавсралт болох “Гаалийн ахмадын байгууллага, ахмад настнуудтай хамтран ажиллах журам”-д өөрчлөлт оруулах саналтай танилцаж саналыг дотоодзурвасаар хүргүүлсэн.<br><br>Санал:- “Ахмадын сангийн журам”-д өгөх санал:<br><br>1.Гаалийн ахмадын хорооноос ирүүлсэн “Гаалийн байгууллагын ахмадын сангийн журам”-ын төсөлд Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын зүйл, заалтуудыг шууд хуулбарлан оруулсан байдлыг хянаж шаардлагатай зүйл, заалтуудыг агуулгын хувьд найруулан тусгах.<br><br>2.Тус журмын төслийн 1.1-ийн “Ахмад настны тухай 2017 оны хуулийн 14.7 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор” гэснийг хасч тушаалын үндэслэх хэсэгт тусгах;<br><br>3.Журмын төслийн “2.1.2.Сангийн тухай жилийн чөлөөт үлдэгдэл хөрөнгө” гэснийг хасах саналтай байгаа бөгөөд Төрийн сан жилийн эцэст дансны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чөлөөт үлдэгдлийг татаж авдаг зохицуулалттай уялдуулах.<br><br>4.Журмын төслийн “2.1.3.Сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого” гэснийг хасах.<br><br>Төслийн “1.4.Ахмадын сангийн хөрөнгийг Төрийн дансанд байршуулна” гэсэнтэй зөрчилдсөн;<br><br>5.Журмын төслийг хууль зүйн техник, Монгол хэлний үсгийн дүрэмд нийцүүлэх, үг хэллэг, нэр томьёо, найруулгыг жигдлэх.<br><br>“Гаалийн ахмадын байгууллага, ахмад настнуудтай хамтран ажиллах журам”-д өгөх санал:<br><br>1.Ахмад настны тухай хууль (2017 оны)-д 2024 онд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Гаалийн ахмадын хорооноос ирүүлсэн танилцуулгад дурдсаны дагуу Гаалийн ахмадын хорооны бүтэц, зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулж цэгцлэх гэсэн үндсэн саналтай байна.<br><br>2.Ахмад настны тухай хуулийн 9 дүгээр зүйл (Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих)-ийн 9.11 хэсгийг хэрэгжүүлэх талаар тус журамд тусгах.<br><br>3.Ахмад настны тухай хуулийн 15 дугаар зүйл (Ахмадын байгууллага)-ийн 15.7 дах хэсгийг хэрэгжүүлж болох тухай заалтыг журамд оруулах.<br><br>4.Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйл (Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ)-ийн 7.6 болон 7.8 дах хэсэгтэй холбоотой заалтыг журамд тодорхой зүйл болгож оруулах.<br><br>5.Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм, Ахмадын сангийн тухай журам, Гаалийн байгууллага, ахмад настнуудтай хамтран ажиллах журмын төсөлд Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас санал авах, гаалийн газар, хороодод хүргүүлж ахмад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | настнуудаар хэлэлцүүлж санал авах ажлыг зохион байгуулах нь зүйтэй.<br><br>7.Боомтын хэлтсээс 01204/24 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн "Санхүүжилтийн гэрээ дүгнэх тухай акт"-ын төсөлд тус хэлтсийн 01200/78 дугаартай дотоод зурвасаар зөвлөмж хүргүүлсэн.<br><br>8.2025 оны 05 дугаар сарын 07-нд "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журам"-ын төслийн Сонсгол-хэлэлцүүлгийг Хорио цээрийн хэлтэстэй хамтран зохион байгуулж хийсэн.<br><br>**Гэрээний хяналтын бүртгэл хийсэн байдал:**<br><br>Иргэний эрх зүйн гэрээ-37.<br>Хөдөлмөрийн эрх зүйн гэрээ-14. | | |
| 2 | Гаалийн ерөнхий газрын даргын баталсан Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг технологид суурилсан ашиглалтын цахим сан болгоход шаардлагатай мэдээллийн баазыг судалж, нэгтгэх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Гаалийн ерөнхий газрын даргын баталсан Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний 35 эрх зүйн актын мэдээллийн баазыг бэлэн болгох. | Нийтээр дагаж мөрдөх 31 захиргааны хэм хэмжээний актыг гаалийн харилцаанд оролцогч, судлаач, гаалийн чиглэлээр суралцагч оюутан, түүнчлэн гаалийн албан хаагч нар чөлөөтэй, нээлттэй уншиж судлах, хялбар ашиглах шийдлийг боловсруулсан.<br><br>Энэ ажлын хүрээнд хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа нийтээр дагаж мөрдөх шинжтэй 31 захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг баазтай "Link"-ээр холбож, актын санг "docx" өргөтгөлөөр бэлтгэж дууссан.<br><br>Цахим санг www.legalinfo.mn "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем"-ийн хуулийн хэлбэрээр Эрх зүйн акт, хавсралт, нэмэлт, өөрчлөлт гэсэн бүтэц, агуулгаар боловсруулбал нийтээр ашиглаж хэвшсэн хэлбэр, загвар тул хэрэглэхэд хүндрэл бэрхшээлгүй үүсэхгүй. | 01.01-06.31 | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бэлтгэсэн мэдээллийн баазыг буюу нийтээр дагаж мөрдөх шинжтэй 31 захиргааны хэм хэмжээний актын цахим санг www.gaali.mn цахим хуудасны нүүрэнд шинэ цонх үүсгэн байршуулах боломжийг програм хангамж, техник, технологи, шийдлийн хувьд судлан үзэж, шийдвэрлэх талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг тус хэлтсийн "Мэргэжил, арга зүйн дэмжлэг хүсэх тухай" 2025 05 дугаар сарын 16-ны өдрийн №01200/250 дотоод зурвасыг хүргүүлсэн.<br><br>Мөн нийтээр дагаж мөрдөх 31 захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, цахим санг МТГ-ын гаалийн улсын байцаагч Б.Энх-Амгаланд цахимаар хүргүүлсэн болно. | | |
| 3 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ<br>Нэгжийн чиг үүргийн хүрээнд захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай эрхийн актыг шинэчлэн найруулж, нэмэлт, өөрчлөлт оруулан, олон нийтэд сурталчлах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шаардлагатай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцоно. | ***Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар***<br><br>ГЕГ-аас гаалийн харилцааг зохицуулж байгаа нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br><br>Үнэлгээг хийхдээ Захиргааны ерөнхий хууль, "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай" ЗГ-ын хуралдааны 2024 оны №39 тэмдэглэл, "Аргачлал батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны №84 тушаалын хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал"-ыг үндэслэсэн болно. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд 2008 оноос хойш ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан"-д бүртгэлтэй нийт 36 захиргааны хэм хэмжээний актыг хамруулснаас дараах үндэслэлээр доор дурдсан 3 хэм хэмжээний актыг | 01.01-12.08 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчингүй болгож, улсын нэгдсэн бүртгэлээс хасуулсан. Үүнд:<br><br>1.“Журам батлах тухай” 2008 оны №660 тушаал *(Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам)*<br><br>Тушаал батлахад үндэслэсэн "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах ажлыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 1995 оны №131 тогтоол “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны №195 тогтоол(*Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам*)-оор хүчингүй болсон.<br><br>2.“Журам батлах тухай” 2008 оны №735 тушаал (*Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх журам*)<br><br>Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх дотоод үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагааг нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ болгож тогтоон, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байсан.<br><br>3.“Заавар батлах тухай” 2016 оны №А/62 тушаал *(Бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах заавар)*<br><br>Гаалийн тухай хуулиар гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах тусгайлсан эрх олгоогүй байхад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ баталж эрх зүйн зөрчил үүсгэсэн.<br><br>Мөн Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг “Журам батлах тухай” ГЕГ-ын даргын 2025 оны №А/19 тушаалаар шинэчлэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталж, хянуулж бүртгүүлэхээр 2025 оны №02/365 албан бичгээр хүргүүлснийг нийтээр заавал дагаж мөрдөх шинжгүй тул гаалийн байгууллага дотооддоо, түүгээрээ мөрдөх чиглэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Шийдвэр буцаан хүргүүлэх, улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийсэн тухай” 2025 оны №1/646 албан бичгээр ирүүлж, улсын нэгдсэн бүртгэлээс хассан тухай мэдэгдсэн.<br><br>Дээрх хүчингүй болсон 3 болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт бус гэж үзсэн 1, нийт 4 эрхийн акт “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан”-гаас хасагдаж 32 нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт хэрэгжиж байна. | | |
| 4 | Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ГЕГ-аас батлан гаргах захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын төслийн хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгсөн байх, | -2023 оноос хойш Авлигатай тэмцэх газраас ГЕГ-ыг хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон эрүүгийн 10 гэмт хэрэгт ГЕГ-ын даргын итгэмжлэлээр хохирогч, иргэний нэхэмжлэгчээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5-ын 4-т заасан хохирогчийн эрх, үүрэг хэрэгжүүлэх хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон оролцож байна.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар 117,4 сая төгрөгний татварыг нөхөн төлүүлэх 2 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ГЕГ-ыг төлөөлөн хохирогч, нэхэмжлэгчээр оролцож “Отбарь” ХХК-д холбогдох 53,1 сая төгрөгийг нэхэмжилж улсын төсөвт дутуу төлсөн дээрх татварыг өнөхөн төлүүлж гаалийн бүрдүүлэлтийг хийлгэсэн болно.<br><br>ХОХИРОГЧ, ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭГЧЭЭР ТОМИЛОГДСОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР АЖИЛЛАСАН БАЙДАЛ<br>/Судалгаа/<br>2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр | 01.01-06.10 | 100% |

| № | Ирсэн албан бичиг | Хэргийн агуулга, дугаар | Ирсэн бичгийн хуулийн үндэслэл | Хариуцса комиссар |
|---|---|---|---|---|
| 1. | **АТГ, МШХ.** 2023.09.19 №06/14765 | ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1,8.5-д заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1, 8.5 | Мөрдөгч, комиссар Г.Амгаланбаа 70112446 |
| 2. | **АТГ, МШХ.** 2023.11.29 №06/19492 | ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1-ийн 3 дахь хэсэг, 9.5-ын 1.2-т заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1-ийн 3, 9.5-ийн 1.2 | Мөрдөгч, комиссар М.Тэмүүжи 70112446 88352226 |
| 3. | **АТГ, МШХ.** 2024.02.02 №06/2223 | СЭГГ-ын ГУБ, ГУАБ, "Их мэргэд оч" ХХК-д холбогдох 8,4 сая төгрөгийн татвар төлөгдөөгүй эрүүгийн хэрэгт ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1,8.5-д заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1, 8.5, 9.5 | Мөрдөгч, комиссар Б.Ариунсайх 92025444 |
| 4. | **АТГ, МШХ.** 2024.02.08 №06/2630 | ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1-ийн 3, 9.5-ын 1.2-т заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1-ийн 3, 9.5-ын 1.2 | Мөрдөгч, комиссар М.Тэмүүжи 70112446 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | **АТГ, МШХ.**<br>2024.02.14<br>№06/2859 | №2302007650045 эрүүгийн хэргийг шалгах явцад гаалийн болон бусад татварт 9.870.182 төгрөг төлөөгүй хохирол учруулсан нөхцөл байдал тогтоогдож ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1, 8.5-д заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1, 8.5, 9.5 | | Мөрдөгч, комиссар Г.А 92005666. 70112448 |
| 6. | **АТГ, МШХ.**<br>2024.03.12<br>№06/4488 | Тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж эрүүгийн хэрэгт ГЕГ-ыг хохирогчоор тогтоосон тул ЭХХШТХ-ийн 8.1-ийн 3г, 9.5-ын 1.2-т заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | ЭХХШТХ. 8.1-ийн 3, 9.5-ын 1.2 | | Мөрдөгч, комиссар М.Тэмүүжи 70112446 |
| 7. | **АТГ, МШХ.**<br>2024.08.29<br>№06/13789 | Чингис хаан олон улсын нисэх буудлын гаалийн хилээр нэр бүхий иргэд арилжааны шинж чанартай хувцас, барааг гаалийн татвар төлөлгүйгээр нэвтрүүлсэн эрүүгийн хэрэгт ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1, 8.5-р зүйлд заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай.<br>/ЧХОУНБГГ-ийн ГУБ Отгончулуун / | ЭХХШТХ. 8.1, 8.5. | | Мөрдөгч, комиссар Б.Баянжаргі 70112556 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| 8. | **АТГ, МШХ.**<br>2024.09.02 №06/13940 | ЧХНБГГ-ын ГУБ нар албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал бий болгосон Эрүүгийн хэрэгт ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1, 8.5-д заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай. | | ЭХХШТХ. 8.1, 8.5. | | Мөрдөгч, комиссар Б.Цолмон 70112403<br>/Мөнх-соно |
| 9. | **АТГ, МШХ.**<br>2025.01.23 №06/1548 | Нэр бүхий ГУБ 2024.11.14-ний өдөр албан үүргээ зориуд хэрэгжүүлэхгүй байж "Отбар" ХХК-д хууль бус давуу байдал бий болгосон, тус компани нь Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь автозамын боомтоор барилгын материал импортлохдоо гаалийн албан татварыг худал мэдүүлж төсөвт 67,4 сая төгрөгийн хохирол учруулсан. | | ЭХХШТХ. 8.1-ийн 3, 9.5-ын 1.2 | | Ахлах мөрдө ахлах комисс Б.Батболд 92000700 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10. | **АТГ, МШХ.** 2025.02.17 №06/3401 | №2429003240009 эрүүгийн хэргийг шалгах явцад гаалийн болон бусад татварт 50.006.490 төгрөгийг төлөөгүй хохирол учруулсан нөхцөл байдал тогтоогдож ГЕГ-ыг ЭХХШТХ-ийн 8.1, 8.5-д заасны дагуу хохирогч, нэхэмжлэгчээр тогтоосон тул ЭХХШТХ-ийн 9.5-д заасны дагуу хууль ёсны төлөөлөгч томилон ирүүлэх тухай.<br>/2022 онд Гашуунсухайт боомтоор нэвтэрсэн 4 чингэлэг бараанд гаалийн хяналт, шалгалт хийхдээ гаалийн улсын байцаагч Наранбаяр татвар дутуу авсан үйлдэлд ӨМА-ийн Цагдаагийн газраас шалгаж эрүүгийн хэрэг үүсгэсэн/ | ЭХХШТХ. 8.1, 8.5, 9.5 | Мөрдөгч, комиссар Э.Золжарга 99962096 |
| 5 | Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг нэгтгэж холбогдох нэгжид хүргүүлэх, | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн үндсэн дээр | Хуулийн хэлтсийн 2025 он Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг бэлтгэх ажил хийгдэж байна | | | 01.01-06.10 | **90%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохирогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна. | | | |
| 6 | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах | Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр | | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | -Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Цагаан Алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улсын Их Хурлаас батлагдсан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, оролцогч талуудын хариуцах арга хэмжээ,төлөвлөлт, санхүүжилт, уялдаа холбоог хангах зорилготой төр, хувийн хэвшлийн анхдугаар зөвлөлдөх уулзалт 2 дугаар сарын 20-ны өдөр болохтой холбогдуулан Хорио цээрийн хэлтсээс ирүүлсэн дотоод зурваст хариу санал, зөвлөмжийг 2025.02.12-ны өдрийн тус хэлтсийн 1200/53 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>-“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн журмуудын төсөлд санал авах тухай” 2025.02.24-ний өдрийн 01/171 дугаартай албан бичгийг ирүүлсэн.<br>Албан бичгийн хавсралтаар ирүүлсэн журмуудын төслийг судлан үзэхэд уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах процессыг хөнгөвчлөх, шат дамжлагыг цөөлөх, түргэн шуурхай худалдах нөхцөлийг бүрдүүлэх, биржийн арилжаанд зарцуулах дундаж хугацааг бууруулах, худалдагч | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаас олон этгээдтэй гэрээ байгуулж байгааг хялбарчлах зэрэг чиглэлээр боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн саналыг “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны төлбөр тооцооны журам”, “Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-д тус тус саналыг ГЕГ-ын дэд даргын 2025.02.28-ны өдрийн 02/936 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах | Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр | | Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана. | 1.“Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” Нийслэлийн прокурор, АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийг тус тус хэрэгжүүлэх, мөн ГЕГ-аас баталсан “АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө” (2024.09.25-2025.09.25)-ний хүрээнд “Авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт”-ыг зохион байгуулан ажиллаж байна.<br><br>2024 онд ЧХОУНБГГ, УБ хот дахь ГГ, ОУШИГГ-т танхимаар, Завхан, Хөвсгөл гаалийн хороо, Орхон, Дархан дахь гаалийн газруудад цахимаар сургалт мэдээллийг хийж байсан бол 2025 оны 04.25-нд Замын-үүд дэх гаалийн газарт “Авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт”-ыг цахимаар зохион байгуулсан.<br><br>Сургалт, мэдээллээр Нийслэлийн прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдэлд дурдсан асуудлаар мэдээлэл хийж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгийн авлига, ашиг | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдосон зохицуулалтаар **38 хуудас** танилцуулга бэлтгэж сургалтад оролцогчдод мэдээлсэн.<br><br>Сургалтад Замын-Үүд дэх гаалийн газрын Гаалийн хяналтын 7 бүс, Чөлөөт бүс, Хяналтын 2 хэсэг болон төв конторын нийт 147 гаалийн улсын байцаагч цахимаар хамрагдсан болно.<br><br>-“Шатахуун тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Цагаан шонхорын жигүүр” НҮТББ-аас “Шатахуун тээвэрлэгчдийн залгамж холбоо” НҮТББ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 21-нд зохион байгуулах тул байгууллагын төлөөлөл оролцуулах хүсэлтийг ГЕГ-ын даргад ирүүлсэн бөгөөд тус хэлэлцүүлэгт оролцож Гаалийн байгууллагатай холбоотой зохих саналыг тавьж оролцсон.<br><br>-Тайлант хугацаанд ГЕГ-ын бүтцийн нэгжүүд болон харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагаанд дараах хууль зүйн мэргэжлийн туслалцаа, зөвлөмжийг 7 удаагийн дотоод зурвас, 2 албан бичгээр хүргүүлж хамтран ажилласан байна. (ЗҮГГ, ЧХОУНБГГ, ЗТГ, ХБГ-т зэрэг) | | |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | -Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажилд оролцсон байна. | ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын журам”-ыг хэлтсийн нийт ГУБ нараар судлуулж эрсдэл болон эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг танин мэдэж, эрсдэлийг удирдахад оролцох үүрэг хариуцлагаа ойлгон үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж болох нэг хүчин зүйл болох хууль, журам, заавар аргачлалаар зохицуулаагүй үйл ажиллагаа, хэрэгжүүлэх боломжгүй буюу бодит байдалд үндэслэгдээгүй журам, заавар боловсруулагдсан | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байх, хууль тогтоомжид нийцээгүй зөрчилдсөн байх, эрхийн актын удиртгал болсон хууль, хуулийн заалт хүчингүй болсон эсэх, ач холбогдлоо алдсан дагаж мөрдөгдөхгүй болсон тушаал, шийдвэр байгаа эсэх дээр байнга хяналт, шинжилгээ хийж ажиллаж байна. | | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | -Хэрэгжилт, гүйцэтгэлээр , хувиар | - | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажиллана. | ГЕГ-аас иргэн, аж ахуйн нэгжтэй хийгдэж байгаа болон Хөдөлмөрийн гэрээнүүдэд нэгдсэн дугаар өгч, хянаж байгаа ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжтэй хийсэн нийт 37 гэрээнд дугаар өгсөн бол хөдөлмөрийн 14 гэрээнд дугаар өгч хяналт тавьж ажилласан байна.<br><br>***2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 16 албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. Үүнд:***<br><br>1.Хариу хүргүүлэх тухай. 2025.06.04. №01-1.2/2382. Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс.<br><br>2.Прокурорын мэдэгдлийн хариу хүргүүлэх тухай. 2025.05.27. №01-1.2/2237. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын прокурорын газар.<br><br>3.Хариу хүргүүлэх тухай. 2025.05.14. №01-1.2/1983. Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Ч.Жадамба.<br><br>4.Хариу хүргүүлэх тухай. 2025.05.08. №01-1.2/1900. Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Б.Жавхланбаяр.<br><br>5.Прокурорын мэдэгдлийн дагуу арга хэмжээ авах тухай. 2025.05.06. №01-1.2/1876. Замын-Үүд дэх гаалийн газар.<br><br>6.Хариу хүргүүлэх тухай. 2025.05.05. №01-1.2/1847. Б.Бат-Эрдэнэ. | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7.Нотлох баримт хүргүүлэх тухай. 2025.04.16. №01-1.2/1526. Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны тойргийн шүүх.<br>8.Нотлох баримт хүргүүлэх тухай. 2025.04.14. №01-1.2/1500. Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүх.<br>9.Нотлох баримт ирүүлэх тухай. 2025.04.10. №01-1.2/1456. Замын-Үүд дэх гаалийн газар.<br>10.Нотлох баримт хүргүүлэх тухай. 2025.04.10. №01-1.2/1457. Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн Анхан шатны тойргийн шүүх.<br>11.Нотлох баримт гаргуулах тухай. 2025.04.08. №01-1.2/1414. Замын-Үүд дэх гаалийн газар.<br>12.Хариу хүргүүлэх тухай. 2025.04.08. №01-1.2/1405. Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа.<br>13.Хариу хүргүүлэх тухай. 2025.02.19. №01/796. Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс.<br>14.Нотлох баримт ирүүлэх тухай. 2025.01.30. №01-1.2/493. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар.<br>15.Хариу хүргүүлэх тухай 2025.01.28. №01/448. Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс.<br>16.Хариу хүргүүлэх тухай. 2025.01.15. №01-1.2/187. Архангай аймгийн насан туршийн боловсролын төв.<br>***2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 24 дотоод албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. Үүнд:*** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1. Мэдээлэл авах тухай. ДХАБХ. №01200/297. 2025.06.06.<br>2. Биелэлт, үр дүнгийн тайлан авах тухай. ХБГ. №01200/295. 2025.06.05.<br>3. Санал хүргүүлэх тухай. ЭУХ. №01200/264. 2025.05.21.<br>4. Мэдээлэл авах тухай. СДШХ. №01200/262. 2025.05.21.<br>5. Санал хүргүүлэх тухай. ХБГ. №01200/255. 2025.05.20.<br>6. Санал хүргүүлэх тухай. СХОГ. №01200/252. 2025.05.19.<br>7. Хариу хүргүүлэх тухай. ХБГ. №01200/248. 2025.05.16.<br>8. Асуулга бөглөж, мэдээлэл хүргүүлэх тухай. ХНХ. №01200/232. 2025.05.09.<br>9. Хариу хүргүүлэх тухай. ХБГ. №01200/167. 2025.04.11.<br>10. Нотлох баримт авах тухай. ГТЛ. №01200/165. 2025.04.09.<br>11. Тайлбар, нотлох баримт гаргуулах тухай. ЗТГ-ын ГУАБ, сахилгын хорооны нарийн бичгийн дарга Т.Сайн-Оюутад. №01200/159. 2025.04.08.<br>12. Нотлох баримт гаргуулах тухай. СДШХ. №01200/157. 2025.04.08.<br>13. Санал хүргүүлэх тухай. СХОГ. №01200/107. 2025.03.14.<br>14. Чиглэл хүргүүлэх тухай. ЗББНДБ. №01200/104. 2025.03.12.<br>15. Санал хүргүүлэх тухай. ГХАХ. №01200/88. 2025.03.06.<br>16. Чиглэл хүргүүлэх тухай. ХТМУТХ. №01200/87. 2025.02.28.<br>17. Зөвлөмж хүргүүлэх тухай. ХТМУТХ. №01200/81. 2025.02.25.<br>18. Санал хүргүүлэх тухай. БХ. №01200/78. 2025.02.25.<br>19. Нэр ирүүлэх тухай. ХБГ. №01200/65. 2025.02.19. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 20. Зөвлөмж хүргүүлэх тухай. ХБГ. №01200/59. 2025.02.17.<br>21. Санал, зөвлөмж хүргүүлэх тухай. ХЦХ. №01200/53. 2025.02.12<br>22. Зөвлөмж хүргүүлэх тухай. ХБГ. №01200/39. 2025.02.05.<br>23. Санал хүргүүлэх тухай. ХБГ. №01200/37. 2025.02.03.<br>24. Санал хүргүүлэх тухай. ТОГ. №01200/14. 2025.01.22. | | |
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана. | Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн №02 тушаалаар аймгийн суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлын хэсэгт **17 өдөр** ажилласан. | 01.01-06.10 | 100% |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна. | Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаартай тушаалаар аймгийн суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлын хэсэг байгуулагдсан.<br>Дээрх тушаалын 2 дугаар хавсралтаар аймаг, суманд ажиллах дэд ажлын хэсгүүдийн хуваарь болон удирдамжийг баталсан бөгөөд дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт Ховд аймгийн Жаргалант, Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Мянгад, Дөргөн сумдууд, Говь-Алтай аймгийн Хөхморьт, | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Жаргалан, Тайшир сумдуудад 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ыг дуустал хугацаанд ажилласан.<br><br>2.Удирдамжид заасан чиглэлийн дагуу Сумдын төрийн байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах, зөвлөн туслах ажлыг дээрх хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.<br><br>Дээрх томилолтын хугацаанд миний бие ажиллахдаа өгсөн чиглэлийн дагуу нийт 2 аймгийн 9 суманд Соёлын төв болон Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал, хүний нөөцийн удирдлага, хүний нөөцийн хүртээмжтэй байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт дээр тодорхой хяналт шалгалт хийх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа байдлыг хянах болон зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br><br>Тухайлбал Ховд аймгийн хэмжээнд 6 сумын 17 цэцэрлэг, 5 Соёлын төв, Говь-Алтай аймгийн 3 сумын гурван Соёлын төв, гурван Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж 600 гаруй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын хувийн хэргийн материалтай танилцаж Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд бүртгэл хэрхэн хөтөлж байгаа байдлыг тулган шалгах, Сумын эрүүл мэндийн төвийн даргын болон Соёлын төвийн эрхлэгчийн гаргасан тушаал шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, төрийн албан хаагч болон тухайн төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал хүсэлт сонсож багийн удирдлагад тухай бүр хүргүүлэх, ажилласан сум бүрийн нийт төрийн албан хаагч нараас Төрийн албаны зөвлөлөөс тусгайлан бэлтгэсэн санал | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуулгын хуудсын дагуу санал асуулга авах, сул орон тоо, төрийн албан хаагч ял шийтгүүлсэн эсэх, албан хаагчдын нас, хүйс, ажилласан жил, шүүхийн маргаантай байгаа албан тушаалын судалгаа авах, Төрийн албаны хууль тогтоомж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, төрийн албан дахь жендерийн судалгаа, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа ямар байгаа, өргөдөл, санал хүсэлтийн бүртгэл, шийдвэрлэлт зэргийг хянаж ажилласан.<br><br>3.Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар батлагдсан дэд ажлын хэсэгт багтаж удирдамжийн дагуу ажилласан бөгөөд өгсөн чиглэлийн дагуу тайланг 20 файлаар Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хүргүүлсэн. Үүнд:<br>1. Ховд болон Говь-Алтай аймгийн сумдуудад ажиллахдаа авсан нэгдсэн судалгаа хүснэгт файлаар.<br>2. Эрдэнэбүрэн сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br>3. Ховд сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br>4. Буянт сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br>5. Мянгад сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br>6. Дөргөн сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br>7. Ховд аймгийн Жаргалант сумын 1-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>8. Ховд аймгийн Жаргалант сумын 14-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>9. Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэгийн үйл ажиллагаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10. Ховд аймгийн Жаргалант сумын 6-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>11. Ховд аймгийн Жаргалант сумын 16-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>12. Ховд аймгийн Жаргалант сумын 2-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>13. Ховд аймгийн Жаргалант сумын 11-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>14. Ховд аймгийн Жаргалант сумын 13-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>15. Ховд аймгийн Жаргалант сумын 8-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>16. Ховд аймгийн Жаргалант сумын 5-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>17. Ховд аймгийн Жаргалант сумын 15-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>18. Ховд аймгийн Жаргалант сумын 7-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>19. Ховд аймгийн Жаргалант сумын 10-р цэцэрлэгийн үйл ажиллагаа.<br>20. Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа файлаар.<br><br>***Татварын орчны шинэчлэл хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар***<br><br>"Татварын хууль тогтоомжийг шинэчлэл" сэдэвт хэлэлцүүлгийн "Гаалийн зуучлагч байгууллагууд, сонирхогч этгээд, гаалийн харилцаанд оролцогчдод зориулсан нээлттэй хэлэлцүүлэг" Гаалийн ерөнхий газрын 9 давхрын хурлын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10.00-12.30, Улаанбаатар хот дахь гаалийн газрын хурлын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 24, 27, 29, 31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Үүнд: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **2025.01.24 10.00-12.30 Баасан гарагт**<br>➢ ТЭЭВЭР ЗУУЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ ГААЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ СОНИРХОГЧ БУСАД ЭТГЭЭД<br>**2025.01.27 10.00-12.30 Даваа гарагт**<br>➢ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ ГААЛИЙН БАТАЛГААТ БҮС ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ ЧӨЛӨӨТ БҮСЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ СОНИРХОГЧ БУСАД ЭТГЭЭД<br>**2025.01.29 10.00-12.30 Лхагва гарагт**<br>➢ ЭМ, ЭМИЙН ЗҮЙЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ИМПОРТЛОГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>➢ СОНИРХОГЧ БУСАД ЭТГЭЭД<br>**2025.01.31 10.00-12.30 Баасан гарагт**<br>➢ УЛС ХООРОНД ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД<br>Нээлттэй хэлэлцүүлгээс иргэн, хуулийн этгээдээс нийт 685 санал ирснийг ангилан, нэгтгэж Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн түүнчлэн нээлттэй хэлэлцүүлэгтэй холбогдуулан гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн.<br>***Нийслэлийн прокурор болон АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр зохион байгуулсан сургалт зохион байгуулсан талаар*** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” Нийслэлийн прокурор, АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийг тус тус хэрэгжүүлэх, мөн ГЕГ-ын “АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө”-ний “Авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт” зохион байгуулах ажлыг зохион байгуулсан.<br><br>Гаалийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч П.Сүхбаатар, Э.Ганболд нар 2025.04.23-ны Лхагва гарагт холбогдож “Авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт”-ыг цахимаар зохион байгуулах талаар мэдэгдэж, сургалтын зар мэдээллийг 2025.04.24-ны өглөө 09:00 цагт, 2025.04.25-ны өдрийн 11 цагт тус тус дотоод сүлжээгээр дамжуулан нийт албан хаагч нарт хүргүүлсэн.<br><br>Сургалт, мэдээллээр Нийслэлийн прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдэлд дурдсан асуудлаар мэдээлэл хийж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Төрийн албны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгийн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдосон зохицуулалтаар **38 хуудас** танилцуулга бэлтгэж сургалтад оролцогчдод мэдээллэв.<br><br>Сургалтад Замын-Үүд дэх гаалийн газрын Гаалийн хяналтын 7 бүс, Чөлөөт бүс, Хяналтын 2 хэсэг болон төв конторын нийт 147 гаалийн улсын байцаагч цахимаар хамрагдсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | -Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх;<br>-Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | - | 1.Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон шийдвэр дээрх байгууллагаас ирээгүй. | 01.01-06.10 | 100% |

**Хоёр.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Хууль тогтоомжийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах | Сургалтын тоо | Зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдсан. | Хууль тогтоомжийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах | Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 01.02-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Байгууллагаас зохион байгуулах болон хөндлөнгийн бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Сургалтын тоо | Удирдлагын академийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалт”-д хамрагдаж сертификат авсан. | Байгууллагаас зохион байгуулах болон хөндлөнгийн бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Байгууллагаас зохион байгуулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | 01.02-06.10 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН ХЭЛСТИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ……………… /П.СҮХБААТАР/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ П.СҮХБААТАРЫН 2025ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | |
| 1. | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал | 60 | 10 | 70 | |
| 2. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ | 60 | 10 | 70 | |
| 3. | Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал | 60 | 10 | 70 | |
| 4. | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 5. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах | 60 | 10 | 70 | |
| 6. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 60 | 10 | 65 | |
| 7. | Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 8. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 9. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна. | 60 | 10 | 70 | |
| 10. | Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах | 60 | 10 | 70 | |
| 11. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | | | | |
| **Дундаж оноо:** | | | | **65.0** | 70 |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | 14 | 14 | |
| 2. | 2025 оноос хос бичгээр албан хэрэгтэй хөтлөхтэй хоргуулан Монгол бичиг бие даан сурах | 14 | 14 | |
| **Дундаж оноо:** | | | **14** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо:** | | **7** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| № | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо: 8** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| № | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 10 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 8 |

| | | |
|---|---|---|
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | - |
| | **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | **90** |

***Үнэлгээ өгсөн:***
***Нэгжийн дарга:***
Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Ч.Тамираа)

2025.06.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***
***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (П.Сүхбаатар)

2025.06.10 (огноо)

***Үнэлгээг хянасан:***
***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

2025.06.25 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн
улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2025.06.25 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***
***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)

---oOo---